ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 25 өдөр Дугаар 176 Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 439,850,046.00 (дөрвөн зуун гучин есөн сая найман зуун наян таван мянга дөчин зургаа) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын хэрэгжилт 93.6 хувь буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсүгэй.

2. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. "Дарханы дулааны цахилгаан станц" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал (М.Жаргалсайхан)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай;

3.1. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.2. Компанийн санхүүгийн тайланд тусгасан, 2010 онд "Дулаан шарын гол" төрийн өмчит хувьцаат компани (гэмтэл, засвар үйлчилгээ хийхэд санхүүгийн дэмжлэг 197.78 сая төгрөг)-тай холбоотой үүссэн авлагыг барагдуулах талаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлэх;

3.3. Компанийн цайны газар, буфет болон "Оч сувилал"-ын хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, (алдагдал 54.9 сая төгрөг) алдагдлыг бууруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан үр ашигтай байх зарчмыг хэрэгжүүлэх;

3.3. Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үнсэн сангийн эзэмшил газрын нэмэгдсэн 92,338 м.кв талбайг үнэлэх, эко авто зогсоолын газар эзэмших эрхийг баталгаажуулж үнэлэх, газар эзэмших эрхийг тус тус санхүүгийн тайланд тусгах арга хэмжээ авах;

3.4. Компанийн эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй, сүүлийн 3 жилд

зарцуулагдаагүй бараа материалыг ангилах, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтгүй байгаа 1 ширхэг нийтийн орон сууцны зориулалттай газар эзэмших эрхийг худалдах зэргээр тус тус эргэлтэд оруулж төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлэх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.6. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг таслан зогсоох;

3.7. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 05 дугаар сарын 11. -ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт

“Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Үнийн дүн (сая төгрөг)	Зөрчигдсөн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Үргүй зардал гаргасан	5.6	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах
2	Үндсэн хөрөнгийг данс хооронд зөвшөөрөлгүй шилжүүлсэн	42.6	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 -р тогтоол	Хууль болон холбогдох журмыг мөрдөж ажиллах
3	Тендер шалгаруулалтын зарчим, журмыг мөрдөөгүй	300.7	"ТБОНӨБАҮХАТ хуулийн 8.4, 8.5 дахь заалт	“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийг мөрдөж ажиллах
4	Захиалагчтай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд хянал тавьж алданги тооцоогүй	28.7	ТБОНӨБАҮХАТ хуулийн 46.1.6 дахь заалт	
5	Шаардлагад нийцээгүй тендер шалгаруулсан	62.2	ТБОНӨБАҮХАТ хуулийн 27.3 дахь заалт	
6	Газар эзэмших эрх үнэлж данс бүртгэлд тусгаагүй	-	Засгийн газрын 2019 оны 10 дугаар тогтоол	Газар эзэмших эрхийг тухай бүр үнэлж бүртгэх
Нийт дүн		439.8 (дөрвөн зуун гучин есөн сая найман зуун тавин мянга дөчин зургаа)		

--o0o--